



## ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/635

Хэрлэн сум

### Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, 78.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан Дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээ-ний тухай журам, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хорин гуравдугаар хуралдааны 05 дугаар Тогтоолд өөрчлөлт оруулах тухай тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хоёрдугаар хуралдааны 2024 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 7 нэрийн 169,300,000 (нэг зуун жаран есөн сая гурван зуун мянган) төгрөгийн балансын үнэ, 132,628,832 (нэг зуун гучин хоёр сая зургаан зуун хорин найман мянга найман зуун гучин хоёр) төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 37,124,166 (гучин долоон сая нэг зуун хорин дөрвөн мянга нэг зуун жаран зургаан) төгрөгийн үлдэх өртөг бүхий тээврийн хэрэгслийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Худалдах эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулах ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Д.Билгээ

Орон нутгийн өмчийн газрын дарга

Хөтлөгч:

С.Сосорбарам

Орон нутгийн өмчийн газрын  
мэргэжилтэн

Тэмдэглэл

хөтлөгч:

Л.Отгончимэг

Орон нутгийн өмчийн газрын хуулийн  
зөвлөх

3. Худалдах эд хөрөнгийн нээлттэй дуудлагын худалдааг 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 106 тоот өрөөнд зохион байгуулсугай.

ЗАСАГ ДАРГА

Д.АЮУРБУНЬ



D:\My Documents\Захирамж-2024

231011705



2024 оны 12 дугаар сарын 05 -ны  
 153 дугаар захирамжийн хавсралт

Үндсэн хөрөнгө худалдах жагсаалт

№	Эзэмшигч байгууллагын нэр	Хөрөнгийн нэр	Улсын дугаар	Үйлдвэрлэсэн, орж ирсэн огноо	Тоо ширхэг	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Байгууллагын санал	ОНӨГ-ын санал	АИТХ-ын шийдвэр	
1	Хэрлэн сумын Засаг даргын тамгын газар	Sonota 7	97-00 ХЭН	2011/2017	1	15,000,000	15,000,000	0	6,000,000	7,000,000	7,000,000	
2	Галшар сумын Засаг даргын тамгын газар	Фургон	98-08 ХЭА	2019/2019	1	35,250,000	30,354,166	4,895,833	8,000,000	10,000,000	10,000,000	
3	Галшар Эрүүл мэндийн төв	Фургон	10-34 ХЭН	2020/2020	1	37,900,000	26,530,000	11,369,999	11,369,999	12,000,000	12,000,000	
4	Биндэр сумын Эрүүл мэндийн төв	Land gruiser 105	30-84 ХЭҮ	2005/2005	1	3,000,000	3,000,000	0	1,500,000	5,000,000	5,000,000	
5	Тахилгат тосгоны Эрүүл мэндийн төв	Фургон	33-01 ХЭҮ	2017/2017	1	29,700,000	29,287,500	412,500	10,000,000	10,000,000	10,000,000	
6	Орон нутгийн өмчийн газар	Land gruiser 200	00-71 ХЭҮ	2007/2008	1	18,750,000	5,729,166	13,020,834	15,000,000	15,000,000	15,000,000	
7	Нэгдсэн эмнэлэг	Фургон	11-28 ХЭА	2017/2018	1	29,700,000	22,728,000	7,425,000	2,500,000	10,000,000	10,000,000	
<b>Нийт</b>						<b>7</b>	<b>169,300,000</b>	<b>132,628,832</b>	<b>37,124,166</b>	<b>54,369,999</b>	<b>69,000,000</b>	<b>69,000,000</b>